



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/49

Есөнбулаг

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 8 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн аварга малчин, аймгийн хошой аварга малчин шалгаруулах журам"-ыг нэгдүгээр, "Аймгийн аварга фермер шалгаруулах журам"-ыг хоёрдугаар, "Аймгийн аварга саальчин шалгаруулах журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн аварга малчин, аймгийн хошой аварга малчин, аймгийн аварга фермер, аймгийн аварга саальчныг шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусган батлуулж, санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д даалгасугай.

3. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг малын чанар, ашиг шимийн үзүүлэлт, тэдний нийгэмд үзүүлж байгаа хувь нэмэр, бэлчээр ашиглалт зэрэг шалгуур үзүүлэлтээр хөдөлмөрийг нь үнэлж, эрэмбэлэн аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хугацаанд нь ирүүлж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Сумдаас ирсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн ажлын үзүүлэлтийг журмын дагуу эрэмбэлэн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/66 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

ନାମ/ପାଠକ/ସ୍ତମ୍ଭ " ୪ " ଶ୍ରୀ. ସାମୁଏଲ

[illegible]

... ५९/३०६ ...
... ..
... ..
... ..

५९/३०६

ॐ नमो भगवते वासुदेवाय ..

[illegible]

ନିମ୍ନଲିଖିତ (କ) ଓ (ଖ) - ର ନିମ୍ନଲିଖିତ ନିୟମାବଳୀ ..

[illegible]

ସମୀକ୍ଷା/ସମୀକ୍ଷାତରଳ ସାରାଂଶ :- ଚିନ୍ତାବଳୀରେ ନିର୍ଦ୍ଧାରିତ/ପ୍ରତି ଦେଖି ଦେଖି ପ୍ରତିଷ୍ଠାନଗୁଡ଼ିକ ..

— ၁။ - အထက်ပါအတိုင်း ဖော်ပြချက်များကို ကြည့်ရှုရန် ရည်ရွယ်ချက်ဖြင့် ပြင်ဆင်ခြင်းဖြစ်သည်။

2. Средства массовой информации

[illegible]

உறுதிப்படுத்தப்பட்டது



2.2.11 Малчин өрхийн гишүүд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдаж шимтгэл төлсөн байх.

2.2.12 Нийт мал сүргийнхээ 15-аас доошгүй хувийг малын индексжүүлсэн даатгалд хамруулсан байх.

2.2.13 Гэмт хэрэг, зөрчлийн холбогдолгүй байх.

Гурав. Тодорхойлох, шалгаруулах

3.1. Аймгийн аварга малчинд тодорхойлохдоо багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын аварга малчин болсноос хойш 3-аас доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, журмын гол болон нийтлэг шалгуур үзүүлэлтийг хангасан малчдыг ажлын үзүүлэлтээр нь эрэмбэлэн сумын Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.2. Аймгийн хошой аварга малчинд тодорхойлохдоо багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн аймгийн аварга малчин болсноос хойш 2-оос доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, журмын гол болон нийтлэг шалгуур үзүүлэлтийг хангасан малчдыг ажлын үзүүлэлтээр нь эрэмбэлэн сумын Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.3. Журмын гол шалгуур үзүүлэлтийг хангаж, хамгийн өндөр оноо авсан 3 хүртэлх малчныг аймгийн хошой аварга малчин өрхөөр, нийт багийн тоогоор 2-оос хэтрэхгүй малчинг аймгийн аварга малчин өрхөөр шалгаруулахаар тодорхойлж, багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, сумын Засаг даргын тодорхойлт, хүсэлтийн хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.4. Аймгийн аварга малчин, аймгийн хошой аварга малчнаар тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ.

3.4.1 Аймгийн аварга малчин өрх /эхнэр, нөхөр/ анкет (журмын нэгдүгээр хавсралт)

3.4.2 Аймгийн хошой аварга малчин өрх /эхнэр, нөхөр/ анкет (журмын хоёрдугаар хавсралт)

3.4.3 Малчны ажил байдлын тодорхойлолт;

3.4.4 Аймгийн аварга малчин өрхийн ажлын үзүүлэлт (журмын гуравдугаар хавсралт)

3.4.5 Аймгийн хошой аварга малчин өрхийн ажлын үзүүлэлт (журмын дөрөвдүгээр хавсралт)

3.4.6 Иргэний үнэмлэхийн хуулбар /эхнэр, нөхөр/;

3.4.7 Малын дансны хуулга сүүлийн 3 жилээр;

3.4.8 Сумын аварга малчны үнэмлэхийн хуулбар;

3.4.9 Аймгийн аварга малчны үнэмлэхийн хуулбар /хошой аварга малчинд хамаарна/

3.4.10 Малын тоо толгойн албан татвар төлсөн тухай цахим лавлагаа;

3.4.11 Малчны нийгмийн даатгал төлсөн тухай цахим лавлагаа;

3.4.12 Малчны эрүүл мэндийн даатгал төлсөн тухай цахим лавлагаа;

3.4.13 Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар, мөнгө төлсөн баримт;

3.4.14 Малчин үржлийн малдаа үзлэг ангилалт хийлгэсэн тухай сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт;

3.4.15 Малчин малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэххамруулсан тухай сумын Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт;

3.4.16 Багийн иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэл;

3.4.17 Сумын Засаг даргын албан хүсэлт;

3.4.18 Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр

3.4.19 Малын тоо толгойн албан татвар тогтоосон тухай сумын Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тогтоолын хуулбар.

3.5. Журмын 3.3-т заасан шалгуур үзүүлэлтийн нотлох баримт, баталгаажуулалтыг хуурамчаар үйлдэхийг хориглоно.

3.6. Малчдын материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад ирүүлсэн байна.

3.7. Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага сумдаас ирсэн малчдын материалыг нэг бүрчлэн хянаж, энэхүү журамд тавигдсан шаардлага шалгуур

үзүүлэлтийг хангасан малчдын материалыг ажлын үзүүлэлтээр эрэмбэлэн аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.8. Тэмээ, үхэр сүргээ тогтвортой өсгөж, ашиг шимийг нэмэгдүүлэх болзолд шалгарсан малчныг аймгийн аварга малчнаар шагнана.

Дөрөв. Шагнал олгох

4.1. Аймгийн аварга малчин өрх тус бүрийг 1.100,0 /Нэг сая нэг зуун мянга/ хүртэлх төгрөгөөр шагнах бөгөөд энэ дүнд цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, бэлэг дурсгал зэрэг дагалдах зүйл багтсан байна.

4.2. Аймгийн хошой аварга малчин өрх тус бүрийг 1.300.0 /нэг сая гурван зуун мянга/ хүртэлх төгрөгөөр шагнах бөгөөд энэ дүнд цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, бэлэг дурсгал зэрэг дагалдах зүйл багтсан байна.

4.3. Аймгийн аварга, аймгийн хошой аварга цолоор шагнагдсан малчны эхнэрт энгэрийн тэмдэг, цолны үнэмлэх олгоно.

4.4. Аймгийн хошой аварга, аймгийн аварга малчны үнэмлэхээр дараах эрхийг эдэлнэ.

1.4.1 Эрүүл мэндийн үйлчилгээг очер дараалал харгалзахгүй авах.

1.4.2 Ардын дуу бүжгийн Алтай чуулгаас зохион байгуулж буй үзвэр үйлчилгээг үнэ төлбөргүй үзэх

1.4.3 Аймгийн орон нутаг судлах музейг үнэ төлбөргүй үзэх.

4.5. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулна.

"Аймгийн аварга малчин шалгаруулах
журам"-ын ... дүгээр хавсралт

"АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН ӨРХ"-ӨӨР ТОДОРХОЙЛОГДОЖ
БУЙ МАЛЧНЫ ТОВЧ АНКЕТ

Цээж зураг /6х4/-ийн
хэмжээтэй

..... он сар өдөр

1	Сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцгийн / эх/ - нэр	
4	Нэр	
5	Төрсөн он , нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн тоо тэдний эрхэлж байгаа ажил	
8	Улсад ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил	
9	Үүнээс: Малчнаар ажилласан хугацаа	
10	Төр, засгаас авсан шагнал, огноо "үнэмлэхийн" дугаар	
11	Сумын сайн малчнаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар	

"Аймгийн аварга малчин шалгаруулах
журам"-ын дугаар хавсралт

" АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН ӨРХ"-ӨӨР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА
..... СУМЫН МАЛЧИН -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

.... он сар өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд		
		... он	... он	... он
Нэг. Малын төрөл, тоо				
Малын үүлдэр омог				
1.Оны эхний мал /бодод шилжүүлснээр/	Бүгд			
Оны эхний малын төрөл	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
2.Хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
Хээлтүүлэгч	Бүгд			
Үүнээс:	Буур			
	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
3.Бойжуулсан төл	Бүгд			
Үүнээс:	Ботго			
	Унага			
	Тугал			
	Хурга			
	Ишиг			
4.Зах зээлд борлуулсан мал	Бүгд			

Үүнээс:	Тэмээ				
	Адуу				
	Үхэр				
	Хонь				
	Ямаа				
5.Үржилд худалдсан мал	Бүгд				
Үүнээс:	Тэмээ				
	Адуу				
	Үхэр				
	Хонь				
	Ямаа				
6.Малжуулахад өгсөн мал	Бүгд				
Үүнээс:	Тэмээ				
	Адуу				
	Үхэр				
	Хонь				
	Ямаа				
7.Зүй бусаар хорогдсон мал	Бүгд				
Үүнээс:	Тэмээ				
	Адуу				
	Үхэр				
	Хонь				
	Ямаа				
8.Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал	Бүгд				
Үүнээс:	Тэмээ				
	Адуу				
	Үхэр				
	Хонь				
	Ямаа				
9.Оны эцэст тоологдсон мал	Бүгд				
Үүнээс:	Тэмээ				
	Адуу				
	Үхэр				
	Хонь				

	Ямаа			
10. Оны эцэст байгаа хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
11. Хээлтүүлэгчийн тохироо	Буур			
	Азарга			
	Бух			
	Хуц			
	Ухна			
Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал				
12. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг/	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
13. Нэг малаас авсан ашиг шим /ноос, ноолуур, сүү/	Тэмээний ноос /кг/			
	Хонины ноос /кг/			
	Ямааны ноолуур /кг/			
14. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	Тэмээний ноос /кг/			
	Хонины ноос /кг/			
	Ямааны ноолуур /кг/			
	Маж үйлдвэрлэл /кг/			
	Сүү /литр/			
15. Мал сүргээ эрүүлжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан байдал	Арга хэмжээний төрөл			
16. Өөрийн хэрэгцээнд бэлтгэсэн өвс, тэжээл /тн/	Өвс			
	Тэжээл			

	Ногоон тэжээл үйлдвэрлэлт /хашиж хамгаалсан талбай/			
17. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа худаг, булаг шанд	Өвөлжөө			
	Хаваржаа			
	Худаг			
	Булаг шандны эх хамгаалсан эсэх			
18. Татвар төлөлт	Төгрөгөөр			
19. Эрүүл мэндийн даатгал	Өрхийн хүн бүр			
20. Нийгмийн даатгалын шимтгэл	Өрхийн хүн бүр			
21. Малын даатгал	Даатгуулсан малын тоо			
	Төлсөн хураамж			

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГА /

/

ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:
ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН
МЭРГЭЖИЛТЭН /

/

__оОо__

Аймгийн хошой аварга малчин шалгаруулах
журам"-ын ... дугаар хавсралт

"АЙМГИЙН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ"-ӨӨР
ТОДОРХОЙЛОГДОЖ БУЙ МАЛЧНЫ ТОВЧ АНКЕТ

Цээж зураг /6х4/-ийн

Хэмжээтэй

..... он сар өдөр

1	Сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцгийн / эх/ - нэр	
4	Нэр	
5	Төрсөн он , нас, хүйс	:
6	Боловсрол	
7	Ам бүлийн тоо тэдний эрхэлж байгаа ажил	
8	Улсад ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил	
9	Үүнээс: Малчнаар ажилласан хугацаа	
10	Төр, засгаас авсан шагнал, огноо "үнэмлэхийн" дугаар	
11	Сумын сайн малчнаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар	
12	Аймгийн аварга малчнаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар	

"Аймгийн хошой аварга малчин шалгаруулах
журам"-ын 4. дүгээр хавсралт

"АЙМГИЙН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ"-ӨӨР ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА..... СУМЫН МАЛЧИН -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

ДТ/АС042

..... он сар өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд	
		... он	... он
Нэг. Малын төрөл, тоо			
Малын үүлдэр омог			
1. Оны эхний мал /бодод шилжүүлснээр/	Бүгд		
Оны эхний малын төрөл	Бүгд		
Үүнээс:	Тэмээ		
	Адуу		
	Үхэр		
	Хонь		
	Ямаа		
2. Хээлтэгч	Бүгд		
Үүнээс:	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
Хээлтүүлэгч	Бүгд		
Үүнээс:	Буур		
	Азрага		
	Бух		
	Хуц		
	Ухна		
3. Бойжуулсан төл	Бүгд		
Үүнээс:	Ботго		
	Унага		
	Тугал		
	Хурга		
	Ишиг		
4. Зах зээлд борлуулсан мал	Бүгд		
Үүнээс:	Тэмээ		
	Адуу		
	Үхэр		
	Хонь		
	Ямаа		

5. Үржилд худалдсан мал		Бүгд		
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
	Бүгд			
6. Малжуулахад өгсөн мал		Тэмээ		
Үүнээс:	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
	Бүгд			
	Тэмээ			
7.Зүй бусаар хорогдсон мал		Адуу		
Үүнээс:	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
8.Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал		Үхэр		
Үүнээс:	Хонь			
	Ямаа			
	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
9.Оны эцэст тоологдсон мал		Хонь		
Үүнээс:	Ямаа			
	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
10.Оны эцэст байгаа хээлтэгч		Ямаа		
Үүнээс:	Бүгд			
	Игэ			
	Гүү			
	Үнээ			
	Ом хонь			
	Ом ямаа			
	Бүүр			
11. Хээлтүүлэгчийн тохироо		Асарга		
	Бух			
	Ал			
	Хана			
	Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал			
12.Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг /		Бүгд		
Үүнээс:		Тэмээ		

	Адуу		
	Үхэр		
	Хонь		
	Ямаа		
13. Нэг малаас авсан ашиг шим /ноос, ноолуур, сүү/	Тэмээний ноос /кг/		
	Хонины ноос/кг/		
	Ямааны ноолуур/кг/		
14. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	Тэмээний ноос /кг/		
	Хонины ноос /кг/		
	Ямааны ноолуур /кг/		
	Мах үйлдвэрлэл /кг/		
	Сүү /литр/		
15. Мал сүргээ эрүүлжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан байдал	Арга хэмжээний төрөл		
16. Өөрийн хэрэгцээнд бэлтгэсэн өвс, тэжээл /тн/	Өвс		
	Тэжээл		
	Ногоон тэжээл үйлдвэрлэлт /хашиж хамгаалсан талбай/		
	Өвөлжөө		
17. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа худаг, булаг шанд	Хаваржаа		
	Худаг		
	Булаг шандны эх хамгаалсан эсэх		
	Төгрөгөөр		
18.Татвар төлөлт	Төгрөгөөр		
19. Эрүүл мэндийн даатгал	Өрхийн хүн бүр		
20. Нийгмийн даатгалын шимтгэл	Өрхийн хүн бүр		
21. Малын даатгал	Даатгуулсан малын тоо		
	Төлсөн хураамж		

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА /

ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН

МЭРГЭЖИЛТЭН /

__оОо__

Аймгийн Засаг даргын 2015 оны
02 дүгээр сарын 16-ны өдрийн 16 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕР ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

ДЮ.10042

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Өндөр ашиг шимт мал, амьтан өсгөн үржүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх болон нийгэмд хувь нэмэр оруулж байгаа эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуй эрхлэгчдийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн 1 фермерийг "Аймгийн аварга фермер"-ээр шалгаруулна.

3. "Аймгийн аварга фермер" шалгаруулан шагнах асуудлыг аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага

Аймгийн аварга фермерээр тодорхойлогдож байгаа эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь дараах нийтлэг шаардлага хангасан байна.

2.1. Өндөр ашиг шимийн чиглэлээр дагнан төрөлжсөн нэг үүлдрийн мал, амьтныг сонгон үржүүлж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх.

2.1.1. Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 15, аж ахуйн нэгж 30-аас доошгүй шилмэл болон нэгдүгээр ангийн үнээтэй, зохиомол аргаар хээлтүүлэг хийдэг, нэг үнээнээс жилд дунджаар 2100-гаас доошгүй литр сүү саасан, сүүний үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

2.1.2. Махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 40, аж ахуйн нэгж 80-аас доошгүй үнээтэй, оны эхний нэг үхрээс 50 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

2.1.3. Махны чиглэлийн хонь үржүүлж байгаа иргэн 150, аж ахуйн нэгж 300-аас доошгүй эм хоньтой, оны эхэнд байсан нэг хониноос 7.5 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

2.1.4. Гахайн аж ахуй эрхэлж байгаа иргэн 8, аж ахуйн нэгж 20-оос доошгүй үндсэн мэгжтэй, мэгж бүрээс жилд 15-аас доошгүй торой бойжуулж, эхний жилд 2.0 тонноос доошгүй мах үйлдвэрлэсэн, мах үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

2.1.5. Өндөглөгч шувуу үржүүлж байгаа өрх, аж ахуйн нэгж нь оны эхэнд 1000-аас доошгүй өндөглөгчтэй, нэг өндөглөгчөөс жилд 250-аас доошгүй өндөг үйлдвэрлэсэн байх.

2.2. Тухайн үүлдрийн мал, амьтны арчилгаа маллагааны технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмж, худагтай байх;

2.3. Үржилд ашиглаж байгаа цөм сүргийн мал нь бүртгэл мэдээллийн санд хамрагдсан байна.

2.4. Мал сүргээ эрүүл байлгах, урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээнд өөрийн санаачилгаар оролцдог байх.

2.5. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулдаг байх.

2.6. Үржлийн алба болон аж ахуй эрхлэгчийн захиалгаар сүүний үхрийн аж ахуй эрхлэгч иргэн жилд 2, аж ахуйн нэгж жилд 4, махны үхэр, хонь, гахайн аж ахуй эрхлэгч иргэн жилд 4, аж ахуйн нэгж 8-аас доошгүй үржлийн мал, гахай бойжуулж, худалдсан байх.

2.7. Сүүний чиглэлийн үхрийн болон махны чиглэлийн аж ахуй эрхлэгч иргэн 5-аас доошгүй га, аж ахуйн нэгж 20-оос доошгүй га газар хашиж хамгаалан олон наст тариалан таримал бэлчээр бий болгох, дарсны ургамал тариалах зэргээр газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах.

2.8. Тэжээл бэлтгэх тоног төхөөрөмжтэй, өөрийн хэрэгцээт тэжээлийн 20-иос доошгүй хувийг бэлтгэдэг байх.

2.9. Ажлын байр 2-оос доошгүйг бий болгосон байх.

2.10. Татварын тухай хуулийн дагуу татвар хураамжийг тогтмол төлсөн байх.

2.11. Малчин өрхийн гишүүд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдаж шимтгэл төлсөн байх.

2.12. Мал сүргээ индексжүүлсэн даатгалд хамруулсан байх.

2.13. Гэмт хэрэг, зөрчлийн холбогдолгүй байх.

Гурав. Тодорхойлох. Шалгаруулах

3.1. Сумын аварга фермер болсноос хойш 3-аас доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, журмын шалгуур үзүүлэлтийг хангасан 1 хүртэлх фермерийг тухайн сумын Засаг даргын Тамгын газраас аймгийн аварга фермерээр шалгаруулахаар тодорхойлж, багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолт хүсэлтийн хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.2. Аймгийн аварга фермерээр шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримт бүрдүүлсэн байна.

а. Фермерийн анкет (энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу);

б. Ажлын үзүүлэлтүүд (энэхүү журмын хоёрдогч дөрөвдүгээр хавсралтын дагуу);

в. Фермерийн ажил байдлын тодорхойлолт;

г. Багийн иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, тэмдэглэл;

д. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр;

е. Холбогдох байгууллага, хүмүүсийн гаргасан баталгаа;

ё. Фермерийн ажлыг газар дээр нь шалгасан сумын Засаг даргын Тамгын газрын дүгнэлт /фото зураг, видео бичлэгийн хамт/;

3.3. Тодорхойлолтод энэ журмын 2-т заасан шалгуур үзүүлэлтийг дараах байгууллага, албан тушаалтан баталгаажуулж, баримтаар нотолсон байна.

а. Багийн Засаг дарга 2.7, 2.8, 2.9-д заасан үзүүлэлт;

б. Сумын Засаг даргын Тамгын газар 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9-т заасан үзүүлэлт;

в. Сумын татвар, нийгмийн даатгалын үлсн байцаагч нар 2.10, 2.11-д заасан үзүүлэлт;

г. Тухайн даатгалын байгууллага 2.12-д заасан үзүүлэлт;

д. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч 2.13 /тодорхойлолт/-д заасан үзүүлэлт;

3.4. Журмын 3.3-т заасан шалгуур үзүүлэлтийн нотлох баримт, баталгаажуулалтыг хуурамчаар үйлдэхийг хориглоно.

3.5. Сумын Засаг даргын Тамгын газар нь энэ журмын шалгуур үзүүлэлтийг хангасан 1 хүртэлх фермерийн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад ирүүлсэн байна.

3.6. Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага сумдаас ирсэн фермерүүдийн материалыг нэг бүрчлэн хянаж, энэхүү журамд тавигдсан шаардлага шалгуур үзүүлэлтийг хангасан фермерүүдийн

материалыг ажлын үзүүлэлтээр эрэмбэлэн 14 хоногт багтаан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Шагнал олгох

4.1. Аймгийн аварга фермерийг 1000,0 /нэг сая/ төгрөгөөр шагнах бөгөөд энэ дүнд цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, бэлэг дурсгал зэрэг дагалдах зүйл багтсан байна.

4.2. Аймгийн аварга цолоор шагнагдсан фермерийн эхнэрт цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгоно.

4.3. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулна.

__oOo__

"Аймгийн аварга фермер шалгаруулах
журам"-ын дүгээр хавсралт

АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА ФЕРМЕРИЙН ТОВЧ АНКЕТ

Цээж зураг /6х4/-ийн
хэмжээ
..... он сар өдөр

1.	Сум. багийн нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцэг /эх/-ийн нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс: малчнаар ажилласан жил	
10.	Төр, засгаас авсан шагнал, огноо	
11.	Сумын аварга фермерээр шалгарсан он, үнэмлэхийн дугаар	

"Аймгийн аварга фермер шалгаруулах
журам"-ын дугаар хавсралт

АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА
..... СУМЫН СААЛИЙН ҮХРИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ
..... -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийн ажлын үзүүлэлт		Онууд		
		... он	... он	... он
1. Үржүүлж байгаа үхрийн үүлдэр				
2. Оны эхэнд байгаа нийт үхэр (тоо)				
Үүнээс: а/ үнээ (тоо)				
б/ бойжуулсан тугал (тоо)				
3. Үржилд худалдсан үхрийн тоо				
Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч				
б/ өсвөр хээлтэгч				
4. Зохиомлоор хээлтүүлсэн үнээний тоо				
5. Оны эцэст тоологдсон нийт үхэр (тоо)				
Үүнээс: Үнээний тоо				
Үйлдвэрлэсэн нийт сүү (тонн)				
6. Саалийн 305 хоногт нэг үнээнээс саасан сүү (литр)				
7. Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн малын тоо				
8. Жилд шаардагдах	тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: Өөрийн хүчээр бэлтгэсэн	Тэжээл (тонн)			
	Дарш (тонн)			
	Өвс (тонн)			
9. Хашиж хамгаалсан талбайн хэмжээ (га)				
10. Нэг үхэрт зарцуулсан тэжээлийн хэмжээ (тэжээлийн нэгж)				
11. Үхрийн байрны багтаамж м2				
12. Ашиглаж байгаа худгийн хүчин чадал литр/сек				

13. Бий болгосон ажлын байрны тоо			
14. Татвар төлөлт /Мян.төг/			
15. Эрүүл мэндийн даатгал /Өрхийн хүн бүр/			
16. Нийгмийн даатгал /Өрхийн хүн бүр/			
17. Малын даатгал / Даатгуулсан малын тоо, төлсөн хураамж/			

ХЯНАСАН: СУМЫН ЗАСАГ ДАРГА

ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Аймгийн аварга фермер шалгаруулах
журам"-ын дугаар хавсралт

АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА
СУМЫН МАХНЫ ҮХЭР (ХОНИНЫ)-ИЙН АЖ АХУЙ
ЭРХЛЭГЧИЙН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

..... оны ... сарын ... өдөр

Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийн ажлын үзүүлэлт	Онууд		
	ОН	... ОН	... ОН
1 Үржүүлж байгаа үхэр /хонь/-ийн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт үхэр /хонь/-ийн тоо			
Үүнээс: а/ хээлтэгч /тоо/			
б/ хээлтүүлэгч /тоо/			
в/ бойжуулсан төл /тоо/			
3. Үржилд худалдсан нийт үхэр /хонь/-ийн тоо			
Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч			
б/ өсвөр хээлтэгч			
4. Зохиомлоор хээлтүүлсэн малын тоо			
5. Оны эцэст тоологдсон нийт мал			
Үүнээс: а/ хээлтэгч /тоо/			
б/ хээлтүүлэгч /тоо/			
6. Үйлдвэрлэсэн нийт мах /тонн/			
7. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг/			
8. Зах зээлд борлуулсан нэг үхэр /хонь/-ийн амьдын жингийн дундаж /кг/			
9. Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн тоо			
10 Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ /тонн/			
Үүнээс: Өөрийн хүчээр бэлтгэсэн	Тэжээл /тонн/		
	Өвс /тонн/		
11 Хашиж хамгаалсан талбайн хэмжээ (га)			

"Аймгийн аварга фермер шалгаруулах
журам"-ын хавсралт

АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА
СУМЫН ГАХАЙ, ШУВУУНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ
..... -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

..... оны сарын өдөр

Үзүүлэлт	Онууд		
	... он	... он	... он
Нэг. Гахайчны ажлын үзүүлэлт			
1. Үржүүлж байгаа гахайн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт гахайны тоо			
а/ үндсэн мэргийн тоо			
б/ үржилд ашиглах бодонгийн тоо			
в/ бойжуулсан нийт торойн тоо			
г/ нэг мэгжнээс бойжуулсан торой			
3. Үйлдвэрлэсэн нийт гахайн мах /тонн/			
4. Маханд борлуулсан нэг гахайн дундаж амьдын жин /кг/			
5. Үржилд худалдсан шалгалтын мэргжийн тоо			
6. Оны эцэст тоологдсон нийт гахай			
Үүнээс: үндсэн мэргжийн тоо			
7. Цөм сүргийн гахайны тоо			
8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ /тонн/			
а/ өөрийн хүчээр үйлдвэрлэсэн /тонн/			
б/ худалдан авсан тэжээл /тонн/			
9. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
10. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
11. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
12. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			
Хоёр. Шувуучны ажлын үзүүлэлт			
Үзүүлэлт	онууд		

	ОН	ОН	.. ОН
1. Үржүүлж байгаа шувууны үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт шувууны тоо			
Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
3. Нийт үйлдвэрлэсэн өндөг (мян. ширхэг)			
Үүнээс: борлуулсан өндөг (мян. ширхэг)			
4 Бойжуулсан дэгдээхэй			
5. Үржилд худалдсан шувуу			
6. Үйлдвэрлэсэн мах (кг)			
7. Эх сүргийн шувууны тоо			
8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тн)			
Үүнээс: өөрийн хүчээр бэлтгэж, үйлдвэрлэсэн (тн)			
- худалдан авсан тэжээл (тн)			
9. Оны эцэст байгаа нийт шувуу			
Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
10. Оруулсан хөрөнгө оруулалт (мян. төг)			
11. Жилийн борлуулалтын нийт орлого (мян. төг)			
12. Жилд олсон цэвэр ашиг (мян. төг)			
13. Нэг ажилчны дундаж цалин (мян. төг)			
14. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян. төг)			

Тайлбар: Үзүүлэлтийг сумын Засаг даргын Тамгын газар шалгаж баталгаажуулна.

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГА /

ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН

__оОо__

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 10-ны өдрийн 49 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

АЙМГИЙН АВАРГА СААЛЬЧИН

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг эзэмшиж, түүнийг боловсронгуй болгох, үйлдвэрлэлд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, малаа саалинд хамруулж, хамгийн их сүү саан боловсруулж байгаа саальчны хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан саальчдын сүүлийн 2 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн 3 хүртэлх саальчинг "Аймгийн аварга саальчин"-аар шалгаруулна.

3. "Аймгийн аварга саальчин" шалгаруулан шагнах асуудлыг аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага

Аймгийн аварга саальчнаар тодорхойлогдож байгаа саальчин дараах шаардлагыг хангасан байна:

- 2.1. Оны эхний хээлтэгч тутмаас бойжуулсан төл нь улсын дунджаас доошгүй байх.
- 2.2. Сүрэгт эзлэх хээлтэгч бог малд 45, бод малд 30-аас доошгүй хувь байх.
- 2.3. Төллөсөн хээлтэгчийн 85 хувийг саалинд хамруулж, нийт саасан сүүний хэмжээ жил дараалан өссөн байх.
- 2.4. Нэг малаас авч байгаа ашиг шим нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байх.
- 2.5. Үржилд ашиглаж байгаа цөм сүргийн мал нь бүртгэл мэдээллийн санд хамрагдсан байна.
- 2.6. Мал сүргээ эрүүл байлгах, урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээнд өөрийн санаачилгаар оролцдог байх.
- 2.7. Иргэн, байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулдаг байх.
- 2.8. Аймаг, орон нутгаас зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд өөрийн хийсэн бүтээгдэхүүнээр тогтмол оролцдог байх.
- 2.9. Хонин толгойд шилжүүлснээр нэг малд 3 кг-аас доошгүй өвстэй тэнцэхүйц хадлан, гар тэжээл, дарш, үйлдвэрийн гаралтай тэжээлийг бэлтгэж нөөцөлсөн байх.
- 2.10. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаагаа үлгэр жишээ тохижуулсан, худаг эсвэл уст цэгтэй байх. Шинээр худаг гаргасан бол тодорхойлолтод тусгасан байх.
- 2.11. Татварын тухай хуулийн дагуу татвар хураамжийг тогтмол төлсөн байх.
- 2.12. Малчин өрхийн гишүүд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдаж шимтгэл төлсөн байх.
- 2.13. Мал сүргээ индексжүүлсэн даатгалд хамруулсан байх.
- 2.14. Гэмт хэрэг, зөрчлийн холбогдолгүй байх.
- 2.15. Аймгийн аварга саальчинд фермерийн аж ахуйн саальчныг хамааруулахгүй.

Гурав. Аварга саальчнаар тодорхойлох, шалгаруулах

3.1. Сүүлийн 3-аас доошгүй жил /энэ шалгуурыг журам хэрэгжсэн эхний 3 жилд мөрдөнө/ сумын аварга саальчин болсноос хойш 2-оос доошгүй жил амжилттай ажиллаж байгаа саальчинг сүүлийн 2 жилийн ажлын үзүүлэлтээр дүгнэж, журмын шалгуур үзүүлэлтийг хамгийн өндөр хангасан нэг саальчныг "Аймгийн аварга саальчин"-аар шагнуулахаар тодорхойлно.

3.2. Аймгийн аварга саальчнаар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

- а. Саальчны товч анкет (энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу);
- б. Ажлын үзүүлэлт (энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу);
- в. Саальчны ажил байдлын тодорхойлолт;

- г. Багийн иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэл, тогтоол;
д. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр;
е. Холбогдох байгууллага, хүмүүсийн гаргасан баталгаа;
ё. Малчны ажлыг газар дээр нь шалгасан сумын Засаг даргын Тамгын газрын дүгнэлт /фото зураг, видео бичлэгийн хамт/;

3.3. Тодорхойлолтод энэ журмын 2-т заасан шалгуур үзүүлэлтийг дараах байгууллага, албан тушаалтан баталгаажуулж, баримтаар нотолсон байна.

- а. Багийн Засаг дарга 2.9, 2.10-т заасан үзүүлэлт;
б. Сумын Засаг даргын Тамгын газар 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9 -т заасан үзүүлэлт;
в. Сумын татвар, нийгмийн даатгалын улсын байцаагч нар 2.11, 2.12-т заасан үзүүлэлт;
г. Тухайн даатгалын байгууллага 2.13-д заасан үзүүлэлт;

д. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч 2.14-д заасан үзүүлэлт /тодорхойлолт/;

3.4. Журмын 3.3-т заасан шалгуур үзүүлэлтийн нотлох баримт, баталгаажуулалтыг хуурамчаар үйлдсэн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

3.5. Сумын Засаг даргын Тамгын газар саальчдыг ажлын үзүүлэлтээр нь эрэмбэлэн сумын Засаг даргын зөвлөл хэлэлцэн шийдвэрлэж, хамгийн өндөр үзүүлэлттэй 1 хүртэлх малчны материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад ирүүлсэн байна.

3.6. Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага сумдаас ирсэн малчдын материалыг нэг бүрчлэн хянаж, энэхүү журамд тавигдсан шаардлага шалгуур үзүүлэлтийг хангасан саальчдын материалыг ажлын үзүүлэлтээр эрэмбэлэн 14 хоногт багтаан Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Шагнал

4.1. Аймгийн аварга саальчин тус бүрийг 400,0 /дөрвөн зуун/ мянгаас доошгүй төгрөгөөр шагнах бөгөөд энэ дүнд цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, бэлэг дурсгал зэрэг дагалдах зүйл багтсан байна.

4.2. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулна.

Аймгийн аварга саальчин" шалгаруулах
журам"-ын хавсралт

АЙМГИЙН АВАРГА СААЛЬЧНААР ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА ХҮНИЙ ТОВЧ АНКЕТ

Цээж зураг /6х4/-

хэмжээтэй

..... оны сарын өдөр

1.	Сум, багийн нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцэг /эх/-ийн нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс: Саальчнаар ажилласан жил	
10.	Төр, засгаас авсан шагнал, огноо	
11.	Сумын аварга саальчнаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар	

"Аймгийн аварга саальчин"
шалгаруулах журам"-ын хавсралт

АЙМГИЙН АВАРГА СААЛЬЧИНД ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА СУМЫН СААЛЬЧИН -НЫ
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

..... оны сарын өдөр

Үзүүлэлт	Малын төрөл /доошгүй/ байх үзүүлэлт/	Онууд	
		. он	.. он
Нэг. Малын төрөл, тоо			
Малын үүлдэр омог			
1. Оны эхний мал бодод шилжүүлснээр	Бүгд		
2. Оны эхний мал	Бүгд		
Үүнээс:	Тэмээ		
	Адуу		
	Үхэр		
	Хонь		
	Ямаа		
3. Хээлтэгч	Бүгд		
Үүнээс:	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
4. Бойжуулсан төл	Бүгд		
Үүнээс:	Ботго		
	Унага		
	Тугал		
	Хурга		
	Ишиг		
5. Зүй бусаар хорогдсон мал	Бүгд		
Үүнээс:	Тэмээ		
	Адуу		
	Үхэр		
	Хонь		
	Ямаа		
6. Орлогод авсан мал	Бүгд		
үүнээс	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
7. Оны эцэст байгаа хээлтэгч	Бүгд		
Үүнээс:	Ингэ		
	Гүү		

	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
8.Бэлтгэсэн тэжээл /тонн/	Өвс		
	тэжээл		
	Гар тэжээл		
Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал			
9. Оны эхний төллөсөн хээлтэгч малаас үйлдвэрлэсэн сүү /л/	Бүгд		
Үүнээс:	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
10. Боловсруулсан цагаан идээ /тонн/	Нийт		
11. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /тонн/	Нийт		
12.Сүү цагаан идээнээс олсон орлого	Бүгд		
Мян төг	Ингэний сүүнээс		
	Гүүний сүүнээс		
	Үнээний сүүнээс		
	Хонины сүүнээс		
	Ямааны сүүнээс		
13. Саалийн хугацаанд нэг хээлтэгчээс саасан байх сүүний доод хэмжээ /литр/	Бүгд		
	Нутгийн монгол 600 л		
	Сарлаг 250 л		
	Хайнаг 900 л		
	Ингэ 80 л		
	Гүү 150 л		
	Ямаа 50 л		
	Хонь 7 л		
14. Татвар төлөлт	Төгрөгөөр		
15. Малын даатгал	Даатгуулсан малын тоо		
	Төлсөн хураамж		
16. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Өрхийн гишүүн бүр		
17.Нийгмийн даатгалын шимтгэл	Өрхийн гишүүн бүр		

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна. Саасан сүүг малын төрөл тус бүрээр тооцож гаргана.

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГА

ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН